



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар A/210

Хархорин сум

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн хөгжлийн санхүүжилтээр Японы Хүүхдийг Ивээх сангийн хэрэгжүүлэх “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийг удирдан чиглүүлэх үүрэг бүхий “Төслийн сумын зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Засаг даргын Тамгын газрын дарга	Х.Лхагвадулам
Гишүүд:	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Б.Батсүрэн
	Ерөнхий боловсролын Орхон сургуулийн захирал	Н.Энхтуяа
	Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал	Г.Энхрийцэцэг
	Ерөнхий боловсролын Гүнзгий сургуулийн захирал	Б.Даваамаа
	Насан туршийн боловсролын багш	У.Дэчмаа
	Ерөнхий боловсролын Орхон сургуулийн Нийгмийн ажилтан	Х.Сүхбат
	Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Нийгмийн ажилтан	Ж.Анхбаяр
	Ерөнхий боловсролын Гүнзгий сургуулийн Нийгмийн ажилтан	Н.Долгорсүрэн
	Санхүү хариуцсан гишүүн	Б.Отгон
	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан гишүүн	Т.Сэрчмаа
	Сурагчийн төлөөлөл	М.Мөнхцэлмүүн
	Эцэг эхийн төлөөлөл	Ш.Батжаргал
	Сайн дурын идэвхтэн	Д.Сандагдорж
Нарийн бичгийн дарга:	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Ж.Солонго

401100411

2. Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, явц үр дүнг жилийн эцэст сумын Засаг даргын зөвлөлийн хуралд мэдээлж ажиллахыг "Төслийн сумын зөвлөл"-ийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны А/105 джгаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



ГОДГЭРЭЛ